

САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ СҮХЭЭГИЙН ОТГОНЖАРГАЛЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл-тийн хувь
	1	2	3	4	5	6	7
ЗОРИЛТ 1. “САЛБАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Арга хэмжээ 1.1 Халдвар судлалын хяналтын чиглэлээр хяналт шалгалтад ашиглах 10.4.1, 10.5.1 кодтой хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, батлуулна.	Шинэчлэн боловсруулсан хяналтын хуудасны тоо	ЭМС-ын 2024 оны А/76 дугаар тушаал	2	Хяналтын чиглэлийн 10.4.1, 10.5.1 кодтой хяналтын хуудаст нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/26 дугаар тушаалаар батлуулсан.	2025.01-2025.02	100
ЗОРИЛТ 2. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
2	Арга хэмжээ 2.1 Эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын үйлдвэр, эм эмнэлгийн хэрэгсэл, ханган нийлүүлэх байгууллага, эмнэлгийн багаж, материалын ариутгалын үйлчилгээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулна.	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга		30%	Эм эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх 38 байгууллага буюу төлөвлөгдсөн 70 объектын 54%-ийг хамруулан урьдчилан сэргийлэх хяналт хийж, 11 байгууллагын дотоод орчны агаараас 11, арчдас 55, халдваргүйжүүлэх бодисын 4, ариун материалын 29 дээж авч, Стандарт хэмжил зүйн хэлтсийн лабораторид шинжлүүлэхэд арчдасны 3.6%-д нянгийн бохирдол илэрсэн. Шалгалтын явцад нийт 269 зөрчил илрүүлэн, 25 байгууллагад 190 заалт бүхий албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, 7 байгууллагад гүйцэтгэлийн хяналт хийхэд албан шаардлагын хэрэгжилт 59.4%-ийн хэрэгжилттэй байна.	2025.02.10-2025.09.15	100

	Дэд арга хэмжээ 2.1.1 Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамж боловсруулж, батлуулан, шалгалтыг зохион байгуулна.	Урьдчилан сэргийлэх шалгалтын удирдамж	-	10%	Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийн төслийг боловсруулан, батлуулж, 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс хяналт шалгалт эхлүүлсэн. Хяналт шалгалтын явцад анхаарах асуудлын талаар аймаг, нийслэлийн улсын байцаагчдад цахим сургалтыг хийн, чиглэл хүргүүлсэн.	2025.02.10- 2025.08.15	100
	Дэд арга хэмжээ 2.1.2 Урьдчилан сэргийлэх шалгалтын дүнг хагас, бүтэн жилээр нэгтгэнэ.	Шалгалтын дүнг нэгтгэн, явцын болон нэгдсэн танилцуулга	-	20%	Урьдчилан сэргийлэх шалгалтын явцын танилцуулга бичиж нэгтгэсэн.	2025.02.10- 2025.08.15	100
	Дэд арга хэмжээ 2.1.3 Урьдчилан сэргийлэх шалгалтын нэгдсэн дүнг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.	Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэр	-	-	Хяналт шалгалт үргэлжилж байна.	2025.02.10- 2025.08.15	100
3	Арга хэмжээ 3.2 Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн эрүүл мэндийн 15 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ.	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга бичсэн байна.	2024 оны шалгалтын нэгдсэн танилцуулга	-	Батлагдсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт шалгалтыг 14 эмнэлэгт хийж, холбогдох хяналтын хуудасны дагуу эрсдлийн үнэлгээ хийхэд 1 их, 11 дунд, 2 бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Увс, Өвөрхангай аймагт хийсэн шалгалтын танилцуулгыг бичиж, шалгалтын ахлахад хүргүүлсэн.	2025.02.10- 2025.09.10	100 93%
	Дэд арга хэмжээ 3.2.1 Увс, Өвөрхангай их дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 9 эрүүл мэндийн байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг гүйцэтгэнэ	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	30%	СХГ-ын даргын баталсан 10-00/22, 10-00/25 дугаартай удирдамжийн дагуу Өвөрхангай аймагт 3 эмнэлэг, 6 сувилал, Увс аймагт 2 эмнэлэгт төлөвлөгөөт шалгалт хийхэд 1 их, 8 дунд, 2 бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 11 эмнэлэгт 198 заалт бүхий албан шаардлагаар хугацаатай үүрэг өгсөн.	2025.04.05- 2025.06.10	100

					Шалгалтын явцад 3 эмнэлгийн дотоод орчноос агаарын 5, арчдасны 70, ариун материалын 5, унд ахуйн усны 1 дээж авч шинжлүүлсэн. Увс аймагт хийсэн шалгалтын дүнг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох газруудад санал хүргүүлсэн.		
	Дэд арга хэмжээ 3.2.2 Нийслэлд их дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 6 эмнэлгийн эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмд хяналт шалгалт хийнэ.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	10%	СХГ-ын даргын баталсан 10-00/05 дугаартай удирдамжийн дагуу Мамба дацан, Монг эм, МУАУ-ы технологийн хүрээлэнд төлөвлөгөөт шалгалт хийхэд 3 эмнэлэг дунд эрсдэлтэй үнэлэгдсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 3 эмнэлэгт 68 заалт бүхий хамтарсан албан шаардлагаар хугацаатай үүрэг өгсөн.	2025.05.10- 2025.09.10	100
	Дэд арга хэмжээ 3.2.3 Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын 50-иас доошгүй хувьд эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилтийг хангуулах талаар сургалт зохион байгуулна.	Сургалтын тайлан	-	15%	Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан Мамба дацан, Увс аймгийн Нэгдсэн эмнэлэг, Өвөрхангай аймгийн Хархорин сумын Энэрэл хархорин Өрхийн эрүүл мэндийн төв, Хужирт сумын Эрүүл мэндийн төв, Ананд, Газарчин, Элма, Сэмжид, Хужирт, Хан хужирт сувиллын эмч ажилчдад Халдварын сэргийлэлт хяналтын тухай ойлголт, ЭТҮХХ-аас сэргийлэх нь сэдэвт сургалтыг 2025 оны 4, 5 дугаар сард зохион байгуулсан. Сургалтад 3 эмнэлэг, 7 сувиллын 180 гаруй эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан. 2025 онд төлөвлөгөөт шалгалтад хамруулахаар зарлагдсан 15 эмнэлгийн 11 буюу 74%-ийг хамруулан байгууллагын сургалт хийсэн.	2025.02.10- 2025.09.10	100

4	Арга хэмжээ 3.3 Ахуйн шавж мэрэгч устгал халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх байгууллагад хийх төлөвлөгөөт шалгалтыг зохион байгуулна.	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Удирдамж боловсруулж батлуулсан байна.	20%	Төлөвлөгөөт шалгалтын удирдамж боловсруулан батлуулж, хяналт шалгалтыг зохион байгуулсан.	2025.02-15-2025.06.05	100
			Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга бичсэн байна.	80%	Ахуйн шавж мэрэгч устгал халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх байгууллагад хийсэн төлөвлөгөөт шалгалтын дүнг нэтгэж, газрын даргад танилцуулсан.		
5	Арга хэмжээ 2.4 Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 52.1-д зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус шалгалт хийнэ.	Удирдамж боловсруулж батлуулсан байна.	-	10%	Удирдлагын шийдвэр, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 38 албан бичиг /хариутай 42/ хүсэлтийг хүлээн авч, хугацаанд нь барагдуулан ажилласан.	Тухай бүр	100
		Төлөвлөгөөт бус шалгалт гүйцэтгэж, танилцуулга бичсэн байна.	-	90%	Иргэний ирүүлсэн гомдлын дагуу Мөнгөн гүүр эмнэлэгт төлөвлөгөөт бус шалгалтыг хийн, илэрсэн зөрчлийг үндэслэн зөрчлийн хэрэг бүртгэл явуулж, 3000 нэгжтэй тэнцэх хэмжээний торгох шийтгэл ногдуулан, хэрэг бүртгэлийг хяналтын прокурорт хянуулсан. Төлөвлөгөөт бус шалгалтын танилцуулгыг бичиж, газрын даргад танилцуулсан болно.	Тухай бүр	100
Зорилт 3. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.							
	Эрүүл ахуйн тухай хуулийн 8.2 Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй, өндөр эрсдэлтэй мал, амьтны гаралтайгаас бусад түүхий эд, бараа бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг экспортлоход эрүүл ахуйн дүгнэлт гаргана.	Шийдвэрлэлт ийн хувь	Хүсэлтийн шийдвэрлэлт		Эрүүл ахуйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу ХӨСҮТ, МҮДЭБ, Реженератив медикал сентр ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу хамар залгиурын арчдас, цусны ийлдэс, шээсний сорьцыг БНСУ, ХБНГУ, Хонг Конг улс руу “Хилээр шинжлэгдэхүүн нэвтрүүлэх тухай” улсын ахлах байцаагчийн 16 дүгнэлт		100

					гаргасан. Үүнд: Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагад ХБНГУ руу допингийн шинжилгээний зорилгоор илгээх шээсний сорьцны 13, ХӨСҮТ-д судалгааны зорилгоор Хонг конг улс руу сорьц илгээх 1,Реженератив медикал сентр ХХК-д оношилгооны зорилгоор БНСУ руу илгээх 2 дүгнэлтийг тус тус гаргасан.		
--	--	--	--	--	---	--	--

Зорилт 4. Орон нутаг дахь улсын (ахлах) байцаагчдыг мэргэжил арга зүй, зөвлөмжөөр хангана.

4.1	Орон нутаг дахь улсын байцаагчдыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулна.	Сургалтын хөтөлбөр боловсруулж батлуулна.	Сургалтын хэрэгцээний үнэлгээнд үндэслэн сургалт зохион байгуулна.	50%	Салбарын хяналтын газрын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнийн дагуу Увс, Өвөрхангай аймагт хийх нэгдсэн шалгалтын хүрээнд Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч З.Баялаг, Л.Алтаншагай нарт Хяналт шалгалтын нийтлэг журам болон Эрүүл мэндийн байгууллагуудад халдвар хамгааллын хяналтын чиглэлээр хяналт хийхэд анхаарах асуудлын талаар газар дээр нь дагалдуулан сургалт хийсэн.	2025.05.05-2025.06.10	100
		Сургалтын тайлан			Сургалтын тайланг бичиж, удирдлагад танилцуулсан болно.		

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	Арга хэмжээ 1. Хувь хүний хөгжлийн сургалтад хамрагдах	Сургалтын гэрчилгээ	-	тухай бүр	Монголын залуу эрдэмтдийн холбооноос зохион байгуулсан “Хувь хүний хөгжил-ээрэг хандлага” сэдэвт цахим сургалтад хамрагдсан.	2025.03.10	100
2	Арга хэмжээ 2.	Сургалтын гэрчилгээ	-		Хугацаа болоогүй	2025.06.15-2025.12.25	100

	Мэргэжлийн чиглэлээр мэргэшүүлэх, чадваржуулах сургалтад хамрагдана.						
3	Арга хэмжээ 3. Нэмэлт ажлууд	Үүрэг даалгаврын биелэлт	-	тухай бүр	Томуу томуу төст өвчний халдварын дэгдэлтийн үед авах арга хэмжээний бэлэн байдалд ХӨСҮТ-д дэмжлэгт хяналтыг хийн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Улаанбурхан өвчний дэгдэлт бүртгэгдсэнтэй холбогдуулан, аймаг, нийслэлийн улсын /ахлах / байцаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, хяналт шалгалтын явцын болон нэгдсэн дүнг 2 удаа нэгтгэн, Шуурхай удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлсэн. Эрүүл мэндийн сайдын албан даалгаврын төсөлд санал хүргүүлэн, албан даалгаврын хэрэгжилтийн явц байдал хяналт хийн ажилласан. Эмнэлгийн хог хаягдлыг боловсруулах төхөөрөмжийн суурилуулалт, ашиглалтын талаар мэдээлэл солилцох, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлүүлэх гарцыг олох зорилгоор төхөөрөмж ханган нийлүүлсэн болон ашиглалт суурилуулалт хариуцсан аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөлүүдтэй уулзах зөвлөлдөх уулзалтыг санаачлан 2025.02.07-ны өдөр НҮБ-ын ажлын байранд зохион байгуулж, ашиглалтыг сайжруулах шийдлийн талаар хэлэлцүүлсэн. Ашиглалтыг сайжруулах талаар Rockwell Sambion (Энэтхэг)- нэрийн төхөөрөмжийн 10 ширхэг сэлбэгийг НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран	2025.01.01-2025.02.15 2025.03.05-2025.03.30 2025.01.01-2025.05.20	100

					хийж, тээвэрлэлтийн асуудлыг шийдвэрлүүлсэн. Эмнэлгийн хог хаягдлыг боловсруулах төхөөрөмжийн технологийн судалгаа хийх асуумжийг боловсруулан, ААНБ-дад хүргүүлсэн. Эмнэлгийн хог хаягдлыг боловсруулах төхөөрөмжийн суурилуулалт, ашиглалтыг сайжруулан Баян-Өлгий, Говь-Алтай аймагт шинээр суурилуулан, 3 аймагт засвар үйлчилгээ хийлгэн ашиглалтыг 15 хувиар нэмэгдүүлсэн.		
					Эрүүл мэндийн салбарын стандартын хэрэгжилт ба эрх зүйн орчин хэлэлцүүлэгт оролцон, салбарын стандартын хэрэгжилтийг хангуулахаар хийгдэж байгаа хяналт шалгалтын мэдээллийг бэлтгэн, УИХ-ын гишүүд, ажлын хэсэгт танилцуулсан. Эрүүл мэнд, Хүнс хөдөө аж ахуй, Барилгын салбарын стандартын хэрэгжилт ба эрх зүйн орчин хэлэлцүүлэгт 02 дугаар сарын 20-ны өдөр оролцож, санал хүргүүлсэн.	2025.02.10- 2025.02.25	

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эрүүл ахуй, халдвар хамгааллын
хяналтын улсын ахлах байцаагч
(Албан тушаал)


...../С.Отгонжаргал/
Нэр, гарын үсэг)

2025.06.10
.....
(Огноо)

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Салбарын хяналтын газрын дарга

...../О.Энхболд/
(Албан тушаал) Нэр, гарын үсэг)

.....
(Огноо)